



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.3, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Агаарын хөлгийн түлшний найрлага тодорхойлох болон бусад лабораторийн багаж” Багц:4 давтамж хэмжигч багаж нийлүүлэх 144/20 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Ж.Сайнбаяр

Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн сорилт, шинжилгээний ахлах инженер

Гишүүд:

Г.Одбаяр

Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн ахлах инженер

Л.Отгонжаргал

Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн химич инженер

Ж.Алтанзул

Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн химич инженер

О.Тэсээ

Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн үл эвдэх сорилын инженер

2. Дээрх ажлыг гэрээнд заасан ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж 2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээн авах комисс /Ж.Сайнбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 0400